



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалт, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Дотоод, гадаадын цэргийн академи, сургууль, дамжаанд суралцах сонсогч, суралцагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ыг нэгдүгээр, “Дотоодын цэргийн академи, сургалт, дамжаанд суралцах суралцагчийг сонгон шалгаруулах комисс”-ыг хоёрдугаар, “Гадаадын цэргийн сургууль, академи, сургалт, дамжаанд суралцах суралцагчийг сонгон шалгаруулах комисс”-ыг гуравдугаар, “Дотоод, гадаадын цэргийн сургууль, академи, сургалт, дамжаанд суралцах суралцагчтай байгуулах гэрээ”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталж, 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (бригадын генерал Д.Ганхуяг), Зэвсэгт хүчний Жанжин штаб (хошууч генерал С.Ганбямба), яамны харьяа байгууллагын дарга, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/281 дүгээр тушаал, мөн сайдын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/212 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

1325100144

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
02 дугаар сарын 04 -ны өдрийн
А/Б/Г. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ДОТООД, ГАДААДЫН ЦЭРГИЙН АКАДЕМИ, СУРГУУЛЬ, ДАМЖААНД
СУРАЛЦАХ СОНСОГЧ, СУРАЛЦАГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ,
СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь батлан хамгаалах салбарын хүний нөөцийг бэлтгэж, сургах, мэргэшүүлэхэд чиглэсэн дотоод, гадаадын цэргийн сургууль, академи, коллеж, дамжаа (цаашид "сургууль, дамжаа" гэх)-нд суралцуулах цэргийн алба хаагч, иргэнд тавигдах шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс болон сонгон шалгаруулалтад оролцож байгаа цэргийн алба хаагч, иргэн (цаашид "элсэгч" гэх)-ий эрх, үүрэг, тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2.Батлан хамгаалах, зэвсэгт хүчний хүний нөөцийг бэлтгэж, сургах, мэргэшүүлэхэд чиглэсэн захиалгын хүрээнд дотоодын Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн батлан хамгаалах удирдлагын академи, цэргийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орнуудын цэргийн дунд сургууль, их, дээд, сургууль, академи, коллеж, сургалт, дамжаанд цэргийн алба хаагч, иргэнийг сонгон шалгаруулж, суралцуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3.Сургууль, дамжаанд элсэгчийг сонгон шалгаруулах, суралцуулахад Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг баримтална.

1.4.Батлан хамгаалах, зэвсэгт хүчний захиалгаар дотоод, гадаадын сургууль, дамжаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтан албан хаагчийг суралцуулж болох бөгөөд суралцах ажилтан албан хаагчийг сонгон шалгаруулж, суралцуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог хууль тогтоомжид зааснаас гадна доор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1."Элсэгч" гэж цэргийн болон бусад сургууль, дамжааны сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн цэргийн алба хаагч, ажилтан албан хаагч, иргэнийг;

2.1.2."Сурагч" гэж дотоод, гадаадын цэргийн дунд сургуульд суралцагчийг;

2.1.3."Сонсогч" гэж Цэргийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасныг;

2.1.4.“Суралцагч” гэж дотоод, гадаадын цэргийн академи, коллеж, дамжаанд суралцаж байгаа байлдагч, түрүүч, ахлагч, офицер, ажилтан албан хаагчийг;

2.1.5. “Цэргийн дунд сургууль” гэж Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа Тэмүүжин өрлөг ерөнхий боловсролын сургууль, ОХУ-ын Суворов, кадетын сургуулийг;

2.1.6.“Цэргийн дамжаа” гэж Үндэсний батлан хамгаалахын их сургууль, батлан хамгаалах мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон гадаадын цэргийн сургуулийн албан тушаалын болон мэргэшүүлэх сургалтыг;

2.1.7.“Цэргийн сургууль” гэж Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, гадаадын цэргийн дунд сургууль, их, дээд сургуулийг;

2.1.8.“Цэргийн академи” гэж Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн батлан хамгаалахын удирдлагын академи, гадаадын цэргийн сургууль, академи, коллежийг;

2.1.9.“Бусад их, дээд, сургууль” гэж гадаадын их, дээд, сургуулийн магистр, түүнээс дээш хөтөлбөрийн сургалтыг;

2.1.10.“Цэргийн анги, байгууллага” гэж Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, байгууллагыг.

Гурав. Сургууль, дамжааны сонгон шалгаруулалтад баримтлах зарчим

3.1.Сургууль, дамжааны сонгон шалгаруулалтыг доор дурдсан зарчмыг баримтлан зохион байгуулна.

3.1.1.Хууль дээдлэх;

3.1.2.Адил тэгш боломжоор хангагдах;

3.1.3.Ил тод, нээлттэй байх;

3.1.4.Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1.Сургууль, дамжаанд сонсогч, суралцагчийг сонгон шалгаруулж, суралцуулах үеийн төрийн захиргааны удирдлагыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “БХЯ” гэх), цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб (цаашид “ЗХЖШ” гэх), цэргийн захиргааны удирдлагыг Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар (цаашид “ТЦК” гэх), цэргийн мэргэжлийн удирдлагыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага (цаашид “анги, байгууллага” гэх) тус тус хэрэгжүүлнэ.

4.2. БХЯ нь дотоод, гадаадын сургууль, дамжаанд суралцуулах мэргэжил, хяналтын тооны захиалга, саналыг БХЯ, ЗХЖШ-ын харьяа анги, байгууллагаас жил бүр хүлээн авч нэгтгэн, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, гадаадын суралцуулагч улс орнуудад уламжлан шийдвэрлэнэ.

4.3.Дотоод, гадаадын сургууль, дамжаанд суралцуулах батлагдсан мэргэжил, хяналтын тооны дагуу сонгон шалгаруулалтыг тухай бүр зохион

байгуулж, сонгон шалгаруулалтад тэнцсэн цэргийн алба хаагч, иргэн, ажилтан албан хаагчийг суралцуулах шийдвэр гаргана.

4.4.Батлан хамгаалах удирдлагын академид элсэгчийн хяналтын тоо, цэргийн мэргэжлийн чиглэлийг жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор яамны харьяа байгууллагууд, төрийн цэргийн байгууллагуудад тус тус хүргүүлнэ.

4.5.Гадаад улсаас Батлан хамгаалахын удирдлагын академид элсэн суралцагчийн нэрийг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор яамны Гадаад хамтын ажиллагааны газраас Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж, суралцуулах, цалинжуулах асуудлыг сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

4.6.ОХУ-ын цэргийн дунд сургуульд элсэгчийн нэрийг тухайн жилийн 06 дугаар сарын 01-ний дотор ОХУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлнэ.

4.7.Дотоод, гадаадын сургууль, дамжаанд элсэгчийг сонгон шалгаруулах комисс, түүний ажиллах журмыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батална.

4.8.Комиссын дарга сонгон шалгаруулалтын дүнг яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батлан хамгаалахын сайдад тус тус танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Тав.Сургууль, дамжаанд суралцагчид тавигдах шаардлага

5.1.Гадаадын цэргийн дунд сургуульд суралцах иргэн (хүүхэд) доорх шаардлага хангасан байна.

5.1.1.Монгол Улсын иргэн байх;

5.1.2.Эцэг, эх, асран хамгаалагч нь зөвшөөрсөн байх, өөрөө суралцах хүсэл сонирхолтой;

5.1.3.Эрүүл мэнд, бие бялдрын шалгуур үзүүлэлт хангасан байх;

5.1.4.Ерөнхий боловсролын сургуулийн тодорхойлолт, сурагчийн хувийн хэрэг, "А" үнэлгээтэй байх;

5.1.5.Сурагч хүлээн авагч буй улсаас тавьж буй тусгайлсан шаардлага.

5.1.6.Эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх.

5.2.Цэргийн дамжаанд элсэн суралцах цэргийн алба хаагч доорх шаардлага хангасан байна.

5.2.1.Цэргийн анги, байгууллагын албан тушаалд ажиллаж байгаа;

5.2.2.Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин нь сүүлийн 2 жилд "Хэвийн" түүнээс дээш үнэлэгдсэн байх;

5.2.3.Түвшин тогтоох үзлэг, цогцолбор ба командлалын шалгалт, сургуулийн жилийн төгсөлтийн шалгалтаар "Сайн" түүнээс дээш үнэлэгдсэн байх;

5.2.4.Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын шийтгэл, ёс зүйн зөрчил гаргаагүй байх;

5.2.5.Эрүүл мэнд, бие бялдрын шалгуур үзүүлэлт хангасан байх;

5.2.6.Цэргийн мэргэжлийн боловсрол, шаталсан сургалтын тогтолцооны дагуу зохион байгуулагдсан сургалт, дамжааг төгссөн байх;

5.2.7.Гадаадын цэргийн сургалт, дамжаанд суралцагчийн хувьд суралцагч хүлээн авагч талаас тавьж буй гадаад хэлний мэдлэгийн шаардлагыг хангасан байх.

5.2.8.Эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх.

5.3.Гадаадын цэргийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албаны байлдагч, түрүүч, ҮБХИС-ийн I-II дамжаанд суралцагч сонсогч, иргэн доорх шаардлага хангасан байна.

- 5.3.1.Монгол Улсын иргэн байх;
 - 5.3.2.Зэвсэгт хүчинд алба хаах сонирхолтой байх;
 - 5.3.3.Элсэгч нь 17-22 настай байх;
 - 5.3.4.Цэргийн тангараг өргөсөн байх;
 - 5.3.5.Ахлагч нарын хувьд Зэвсэгт хүчинд тасралтгүй 2-оос доошгүй жил ажилласан байх;
 - 5.3.6.Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын шийтгэл, ёс зүйн зөрчил гаргаагүй байх;
 - 5.3.7.Эрүүл мэнд, бие бялдрын шалгуур үзүүлэлт хангасан байх;
 - 5.3.8.Элсэлтийн ерөнхий шалгалтыг Математик, физик, нийгэм, хими, гадаад хэл хичээлээр өгч, босго оноо 550-аас доошгүй оноотой байх;
 - 5.3.9.Эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх.
- 5.4.Цэргийн академид суралцах офицер нь доор дурдсан шаардлага хангасан байна.
- 5.4.1.Дотоод, гадаадын цэргийн их, дээд сургууль төгссөн, цэргийн ухааны бакалавраас доошгүй зэрэгтэй, голч дүн 3 ба түүнээс дээш дүнтэй байх;
 - 5.4.2.Дотоод, гадаадын цэргийн их, дээд, сургуульд рот, батальон, дивизионы захирагчийн албан тушаалын сургалтад хамрагдаж, төгссөн байх;
 - 5.4.3.Батальон (дивизион)-ы захирагчийн орлогч, тусгай салбарын захирагч, түүнтэй адилтгах буюу түүнээс дээш албан тушаалд 2-оос доошгүй жил ажиллаж байгаа;
 - 5.4.4.Офицерын албан тушаалд 8 ба түүнээс дээш жил ажилласан, ахмад түүнээс дээш цэргийн цолтой, 37 хүртэлх настай (Агаарын цэргийн анги, салбарын нисгэгчийн мэргэжилтэй офицер нь 37 хүртэлх настай) байх;
 - 5.4.5.Хариуцсан алба, салбар, нэгж, тасаг нь сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “Хэвийн” түүнээс дээш үнэлэгдсэн байх,
 - 5.4.6.Түвшин тогтоох үзлэг, цогцолбор ба командлалын шалгалт, сургуулийн жилийн төгсөлтийн шалгалтаар “Сайн” түүнээс дээш үнэлэгдсэн байх;
 - 5.4.7.Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын шийтгэл, ёс зүйн зөрчил гаргаагүй байх;
 - 5.4.8.Эрүүл мэнд, бие бялдрын шалгуур үзүүлэлт хангасан байх;
 - 5.4.9.Гадаад хэлний анхан болон түүнээс дээш мэдлэгтэй, компьютерын хэрэглээний үндсэн программуудыг зохих түвшинд эзэмшсэн байх;
 - 5.4.10.Эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх.
- 5.5.Гадаадын бусад их, дээд, сургуульд суралцах ажилтан албан хаагч нь доор дурдсан шаардлага хангасан байна.
- 5.5.1.Монгол Улсын иргэн байх;
 - 5.5.2.Дотоод, гадаадын их, дээд сургууль төгссөн, бакалавраас доошгүй зэрэгтэй, голч дүн 3 ба түүнээс дээш дүнтэй байх;
 - 5.5.3.Цэргийн анги, байгууллагад сүүлийн 10 жил тасралтгүй ажилласан байх;
 - 5.5.4.Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин нь сүүлийн 2 жилд “Хангалттай” үнэлэгдсэн байх;
 - 5.5.5.Элсэгч нь 22-45 настай байх;
 - 5.5.5.Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын шийтгэл, ёс зүйн зөрчил гаргаагүй байх;
 - 5.5.6.Эрүүл мэнд, бие бялдрын шалгуур үзүүлэлт хангасан байх;

5.5.7. Эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх.

Зургаа. Бүрдүүлэх баримт бичиг, материал

6.1. Гадаадын цэргийн дунд сургуульд суралцах иргэн (хүүхэд) доорх баримт бичиг, материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- 6.1.1. Төрсний гэрчилгээний лавлагаа;
- 6.1.2. Эцэг, эх, асран хамгаалагч суралцуулахыг хүссэн өргөдөл;
- 6.1.3. Цээж зураг 3*4 харьцаатай (2 хувь);
- 6.1.4. Ерөнхий боловсролын сургуулийн тодорхойлолт, өмнөх хичээлийн жилийн төгсөлтийн шалгалтын дүнгийн тодорхойлолт;
- 6.1.5. Сурагчийн хувийн хэрэг, суурь боловсролын гэрчилгээ;
- 6.1.6. Гадаад паспортын хуулбар (паспортын хугацаа хүчинтэй байх);
- 6.1.7. Цагдаагийн байгууллагын тодорхойлолт (Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай лавлагаа);
- 6.1.8. Суралцуулах сургууль, дамжаанаас шаардсан бусад баримт материал.

6.2. Цэргийн дамжаанд элсэн суралцах цэргийн алба хаагч доорх баримт бичгийг бүрдүүлнэ.

- 6.2.1. Элсэн суралцахыг хүссэн өргөдөл;
- 6.2.2. Цээж зураг 3*4 харьцаатай (2 хувь);
- 6.2.3. Төрийн албан хаагчийн анкет, ажил байдлын тодорхойлолт;
- 6.2.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт (и-монголиа), албан тушаалын болон мэргэшүүлэх сургалт, дамжаанд хамрагдсан сертификат, гэрчилгээний хуулбар;
- 6.2.5. Офицер, ахлагчийн үнэмлэхийн хуулбар;
- 6.2.6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь сүүлийн 2 жилд "Хэвийн" түүнээс дээш үнэлэгдсэн үнэлгээний хуулбар;
- 6.2.7. Цэргийн алба хаагчийн сурлагын дэвтрийн хуулбар (сүүлийн 2 жилд хамрагдсан түвшин тогтоох, цогцолбор, командлалын шалгалтаар "Сайн" түүнээс дээш үнэлэгдсэн дүн);
- 6.2.8. Анги, байгууллагын даргын санал, зөвшөөрөл;
- 6.2.9. Сахилгын шийтгэлтэй эсэх талаарх анги, байгууллагын тодорхойлолт;
- 6.2.10. Гадаад паспортын хуулбар (паспортын хугацаа хүчинтэй байх);
- 6.2.11. Цагдаагийн байгууллагын тодорхойлолт; (Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай лавлагаа)
- 6.2.12. Суралцуулах сургууль, дамжаанаас шаардсан бусад баримт материал.

6.3. Гадаадын цэргийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албаны байлдагч, түрүүч, ҮБХИС-ийн I-II дамжаанд суралцагч сонсогч, иргэн доорх баримт бичиг, материалыг бүрдүүлнэ.

- 6.3.1. Элсэн суралцахыг хүссэн өргөдөл,
- 6.3.2. Цээж зураг 3*4 харьцаатай (2 хувь);
- 6.3.2. Төрийн албан хаагчийн анкет, ажил байдлын тодорхойлолт;
- 6.3.3. Бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар;

- 6.3.4.Элсэлтийн ерөнхий шалгалтын онооны хуулбар;
- 6.3.5.Иргэний үнэмлэх, ахлагчийн үнэмлэхийн хуулбар;
- 6.3.6.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь сүүлийн 2 жилд “Хэвийн” түүнээс дээш үнэлэгдсэн үнэлгээний хуулбар (Зөвхөн ахлагч);
- 6.3.7.Цэргийн алба хаагчийн сурлагын дэвтрийн хуулбар;
- 6.3.8.Анги, байгууллагын даргын санал, зөвшөөрөл;
- 6.3.9.Сахилгын шийтгэлтэй эсэх талаарх анги, байгууллагын тодорхойлолт;
- 6.3.10.Гадаад паспортын хуулбар (паспортын хугацаа хүчинтэй байх);
- 6.3.11.Цагдаагийн байгууллагын тодорхойлолт; (Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай лавлагаа)
- 6.3.12.Суралцуулах сургууль, дамжаанаас шаардсан бусад баримт материал.

6.4.Цэргийн академид суралцах офицер нь доор дурдсан баримт бичиг, материалыг бүрдүүлсэн байна.

- 6.4.1.Элсэн суралцахыг хүссэн өргөдөл,
- 6.4.2.Цээж зураг 3*4 харьцаатай (2 хувь);
- 6.4.3.Төрийн албан хаагчийн анкет, ажил байдлын тодорхойлолт;
- 6.4.4.Бакалаврын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт (и-монголиа);
- 6.4.5.Албан тушаалын болон мэргэшүүлэх сургалт, дамжаанд хамрагдсан сертификат, гэрчилгээний хуулбар;
- 6.4.6.Иргэний үнэмлэх, офицерын үнэмлэхийн хуулбар;
- 6.4.7.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь сүүлийн 2 жилд “Хэвийн” түүнээс дээш үнэлэгдсэн үнэлгээний хуулбар;
- 6.4.8.Цэргийн алба хаагчийн сурлагын дэвтрийн хуулбар (сүүлийн 2 жилд хамрагдсан түвшин тогтоох, цогцолбор, командлалын шалгалтаар “Сайн” түүнээс дээш үнэлэгдсэн дүн);
- 6.4.9.Анги, байгууллагын даргын санал, зөвшөөрөл;
- 6.4.10.Сахилгын шийтгэлтэй эсэх талаарх анги, байгууллагын тодорхойлолт;
- 6.4.11.Гадаад паспортын хуулбар (паспортын хугацаа хүчинтэй байх);
- 6.4.12.Цагдаагийн байгууллагын тодорхойлолт; (Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай лавлагаа)
- 6.4.13.Суралцуулах сургууль, дамжаанаас шаардсан бусад баримт материал.

6.5.Гадаадын бусад их, дээд, сургуульд суралцах ажилтан албан хаагч нь доор дурдсан баримт бичиг, материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- 6.5.1.Элсэн суралцахыг хүссэн өргөдөл;
- 6.5.2.Цээж зураг 3*4 харьцаатай (2 хувь);
- 6.5.3.Төрийн албан хаагчийн анкет, ажил байдлын тодорхойлолт;
- 6.5.4.Бакалаврын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт (и-монголиа);
- 6.5.5.Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 6.5.6.Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин нь сүүлийн 2 жилд “Хангалттай” үнэлэгдсэн үнэлгээний хуулбар;

- 6.5.7.Анги, байгууллагын даргын санал, зөвшөөрөл;
 - 6.5.8.Сахилгын шийтгэлтэй эсэх талаарх анги, байгууллагын тодорхойлолт;
 - 6.5.9.Гадаад паспортын хуулбар (паспортын хугацаа хүчинтэй байх);
 - 6.5.10.Цагдаагийн байгууллагын тодорхойлолт; (Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай лавлагаа)
 - 6.5.11.Суралцуулах сургууль, дамжаанаас шаардсан бусад баримт материал.
- 6.6.Энэ журмын 6.1-6.5-т заасан баримт бичиг, материалын үнэн зөв байдлыг элсэгч өөрөө хариуцах бөгөөд баримт бичиг, материалын бүрдүүлбэр дутуу, эсхүл хангаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтын бүртгэлээс хасна.

Долоо.Сургууль, дамжааны сонгон шалгаруулалт

7.1.Сургууль, дамжааны сонгон шалгаруулалтыг дараах үе шаттайгаар зохион байгуулна.

7.1.1.Нэгдүгээр үе шат: Сургалтын цахим системийн бүртгэл, сонгон шалгаруулалтын шаардлага, элсэгчийн бүрдүүлэх баримт бичиг, материалыг хянах, бүртгэлийн баталгаажилт, эрүүл мэндийн үзлэгт хамруулах гэсэн дарааллаар зохион байгуулна.

7.1.2.Хоёрдугаар үе шат: Бие бялдрын болон онолын цогцолбор шалгалт гэсэн дарааллаар зохион байгуулагдана.

7.2.Сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатыг доорх байдлаар зохион байгуулна.

7.2.1.Сургууль, дамжааны сонгон шалгаруулалтын талаар нийтэд мэдээлсэн зарлал, мэдээллийн дагуу цэргийн алба хаагч, иргэн, ажилтан албан хаагч нар өөрийн элсэн суралцахыг хүссэн сургууль, дамжааны хуваарийн дагуу “Батлан хамгаалахын сургалтын цахим систем”-д бүртгүүлж, тогтоосон хугацаанд энэ журмын 6 дугаар зүйлд заасан баримт бичиг, материалыг Сонгон шалгаруулалт зохион байгуулах байнгын комисст өөрийн биеэр хүлээлгэн өгнө.

7.2.2.Байнгын комисс нь сургалтын цахим системд бүртгүүлсэн цэргийн алба хаагч, иргэн, ажилтан албан хаагчдын бүртгэлийг цахимаар хянаж, тэдний бүрдүүлсэн баримт бичиг, материалыг энэ журмын 5-6 дугаар зүйлд заасан шаардлага, бүрдүүлбэртэй нэг бүрчлэн тулгаж, шаардлага хангасан тохиолдолд цахим бүртгэлийн баталгаажуулна.

7.2.3.Үндэсний батлан хамгаалахын их сургууль, батлан хамгаалахын мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд богино хугацаа (1-6 сар хүртэл)-гаар суралцахаас бусад дотоод, гадаадын сургууль, дамжаанд элсэгч нь Цэргийн төв эмнэлгийн эмч нарын үзлэгээр орж, эрүүл мэндийн дүгнэлт гаргуулсан байна. Элсэгч нь эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг өөрөө хариуцна.

7.2.4.Цахим бүртгэл баталгаажсан, эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн цэргийн алба хаагч, иргэн, ажилтан албан хаагчийг дараагийн шалгалтад хамруулах шийдвэрийг байнгын комисс гаргана.

7.3.Сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатыг доорх байдлаар зохион байгуулна.

7.3.1.Эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн элсэгчээс суралцахаар бүртгүүлсэн сургууль, дамжаанаас хамаарч “Цэргийн биеийн тамирын заавар-18”-

ын дагуу доорх хүснэгтэд заасан нормативын үзүүлэлтээр бие бялдрын шалгалтыг авч, комисс дүгнэлт гаргана.

| д/д | Сургууль, дамжааны нэр | Гүйцэтгэх норматив (эрэгтэй) | | Гүйцэтгэх норматив (эмэгтэй) | | Үнэлэх аргачлал (Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартын үнэлгээгээр) |
|-----|--------------------------------|---|---|---|---|--|
| | | 5, 6, 7, 8, 9, 10 дугаар сард | 11, 12, 1, 2, 3, 4 дүгээр сард | 5, 6, 7, 8, 9, 10 дугаар сард | 11, 12, 1, 2, 3, 4 дүгээр сард | |
| 1 | Гадаадын цэргийн дунд сургууль | ЦБТЗ-18-ын 19, 20, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 19, 20, 33, 34 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 19, 20, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 19, 20, 33, 34 дугаар дасгал | Тэнцүүлэх доод үнэлгээ 60 оноо |
| 2 | Цэргийн сургууль | ЦБТЗ-18-ын 7, 20, 32, 37 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 7, 20, 33, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 20, 22, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 20, 22, 33, 35 дугаар дасгал | Тэнцүүлэх доод үнэлгээ 65 оноо |
| 3 | Цэргийн дамжаа | ЦБТЗ-18-ын 7, 14, 32, 37 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 7, 14, 33, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 22, 28, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 22, 28, 33, 35 дугаар дасгал | Тэнцүүлэх доод үнэлгээ 65 оноо |
| 4 | Цэргийн академи | ЦБТЗ-18-ын 20, 22, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 20, 22, 33, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 20, 22, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 20, 22, 33, 35 дугаар дасгал | Тэнцүүлэх доод үнэлгээ 70 оноо |
| 5 | Бусад их, дээд, сургууль | ЦБТЗ-18-ын 19, 20, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 19, 20, 33, 34 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 19, 20, 32, 35 дугаар дасгал | ЦБТЗ-18-ын 19, 20, 33, 34 дугаар дасгал | Тэнцүүлэх доод үнэлгээ 60 оноо |

7.3.2. Онолын цогцолбор шалгалтыг гадаадын цэргийн дунд сургуульд суралцахаар бүртгүүлсэн элсэгчээс хэл, найруулга зүйн бичгийн, төгсөлтийн шалгалтын дүн, гадаадын цэргийн бакалаврын хөтөлбөрт суралцахаар бүртгүүлсэн элсэгчээс хэл, найруулга зүйн бичгийн, гадаад хэлний, элсэлтийн ерөнхий шалгалтын оноо, цэргийн дамжаанд суралцахаар бүртгүүлсэн элсэгчээс бичгийн, хууль, эрх зүй, гадаад хэл (дотоодын цэргийн дамжаанд элсэгчид хамаарахгүй)-ний, цэргийн академид суралцахаар бүртгүүлсэн элсэгчээс ерөнхий тактикийн цогцолбор, хэл, найруулга зүйн бичгийн, хууль, эрх зүй, гадаад хэлний, бусад их, дээд, сургуульд суралцахаар бүртгүүлсэн элсэгчээс хэл, найруулга зүйн бичгийн, хууль, эрх зүйн, гадаад хэлний шалгалтыг тус тус авч, дүгнэнэ.

7.3.3. Ерөнхий тактикийн цогцолбор шалгалт нь элсэлтийн үндсэн шалгалт байх бөгөөд онолын болон дадлагын хэлбэрээр явуулна. Онолын шалгалтыг Байлдааны дүрэм (БД-2/100)-ийн түвшинд төрөл, тусгай мэргэжлийн салбаруудыг хэрэглэх, бүх төрлийн хангалт, удирдлагыг зохион байгуулах асуудлын хүрээнд тестээр, дадлагын шалгалтыг тактикийн шуурхай дадлага (тусгай тэмдэг дарсан цаасан дээр гүйцэтгэх ба тактикийн шуурхай дадлагыг цэргийн байр зүйн зураг дээр боловсруулах)-аар тус тус боловсруулна.

7.3.4. Хэл, найруулга зүйн бичгийн шалгалтыг элсэгчийн найруулга зүйн ур чадварын түвшнийг тогтоох зорилгоор “Эсээ” бичих аргаар явуулна. Элсэгч комиссын бэлтгэсэн сэдвээс сонгож 250-300 үгтэй “Эсээ”-г 45 минутын хугацаанд бичнэ.

7.3.5. Хууль, эрх зүйн шалгалтыг батлан хамгаалахын болон холбогдох бусад хууль тогтоомж, “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хүрээнд тестийн аргаар зохион байгуулна.

7.3.6. Гадаад хэлний шалгалтыг англи болон бусад хэлнээс сонгож, тестийн аргаар зохион байгуулна.

7.3.7. Онолын цогцолбор шалгалтыг элсэгчийн суралцахаар

бүртгүүлсэн сургууль, дамжаанаас хамаарч дараах байдлаар дүгнэх ба шалгалт тус бүр нь дараах оноотой байна.

| д/д | Сургууль, дамжааны нэр | Шалгалтын төрөл | | | | | Онолын шалгалтын үнэлгээ (Нийт авбал зохих оноо) |
|-----|--------------------------------|--|---------------------------------------|-----------------------------------|-------------------------------|---|--|
| | | Ерөнхий тактикийн цогцолбор (Авбал зохих оноо) | Хэл, найруулга зүй (Авбал зохих оноо) | Хууль, эрх зүй (Авбал зохих оноо) | Гадаад хэл (Авбал зохих оноо) | Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо/Төгсөлтийн шалгалтын дүн | |
| 1 | Гадаадын цэргийн дунд сургууль | - | 50 оноо | - | - | 50 оноо | 100 оноо |
| 2 | Цэргийн сургууль | - | 15 оноо | 15 оноо | 20 оноо | 50 оноо | 100 оноо |
| 3 | Цэргийн дамжаа (Дотоод) | - | 40 оноо | 60 оноо | - | - | 100 оноо |
| | Цэргийн дамжаа (Гадаад) | - | 20 оноо | 30 оноо | 50 оноо | - | 100 оноо |
| 4 | Цэргийн академи | 50 оноо | 20 оноо | 15 оноо | 15 оноо | - | 100 оноо |
| 5 | Бусад их, дээд, сургууль | - | 20 оноо | 30 оноо | 50 оноо | - | 100 оноо |

Тайлбар:

- Гадаадын цэргийн дунд сургуульд элсэгчийн төгсөлтийн шалгалтын дүн, сонгон шалгаруулалтаар авсан хэл, найруулга зүйн шалгалтын дүнг нэмж, нэгтгэн тооцно.

Төгсөлтийн шалгалтын дүн 95 "А үнэлгээ" ($95 \cdot 50 / 100 = 47,5$ оноо) + сонгон шалгаруулалтаар авсан 50 оноо = 97,5 оноо

- Гадаадын цэргийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын авбал зохих 800 оноог сонгон шалгаруулалтын үнэлгээгээр 50 оноогоор тооцож, хэл найруулга зүй, хууль, эрх зүй, гадаад хэлний мэдлэгийн шалгалтын авбал зохих 50 оноог нэмж, нэгтгэн нийт үнэлгээг тооцно.

ЭШ 550 оноо ($550 \cdot 50 / 800 = 34,3$ оноо) + сонгон шалгаруулалтаар авсан 50 оноо = Нийт үнэлгээ 84,3 оноо

7.5.Элсэгчдийн нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд Ерөнхий тактикийн цогцолбор, Хэл, найруулга зүйн бичгийн, Гадаад хэлний шалгалт гэсэн дарааллаар шалгалтын оноог харгалзан шийдвэрлэнэ.

7.6.Сонгон шалгаруулалтын дүнг элсэгчдийн цахим системийн хувийн бүртгэлийн дугаар (шифр)-ын дагуу нээлттэй зарлах ба шалгалтын материалтай элсэгчийг танилцуулж гарын үсгийг нь зуруулна. Комиссын гишүүд сонгон шалгаруулалтын материал, дүнгийн хүснэгттэй танилцан гарын үсэг зурж баталгаажуулна.

7.7. Гадаадын цэргийн дунд сургуульд элсэгч нарыг төгсөлтийн шалгалтын дүн, сонгон шалгаруулалтаар авсан онооны нийлбэрээр эрэмбэлэн жагсааж, суралцуулна. Элсэгч нарын оноо тэнцсэн тохиолдолд Монгол хэл, Математикийн хичээлийн дүнгээр эрэмбэлэнэ.

7.8.Гадаадын цэргийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэгч нарыг элсэлтийн ерөнхий шалгалтын оноо, сонгон шалгаруулалтаар авсан онооны нийлбэрээр эрэмбэлэн жагсааж, сургуулийн хуваарийг сонгуулна. Гадаадын цэргийн дунд сургууль болон Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа

“Тэмүүжин-Өрлөг” ерөнхий боловсролын сургуулийг “А” үнэлгээтэй төгссөн элсэгчийн хүсэлтийг харгалзан эхний ээлжинд сургуулийн хуваарийг сонгуулна. Элсэгч нарын оноо тэнцсэн тохиолдолд элсэх мэргэжлийн чиглэлийн гол хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дарааллаар эрэмбэлнэ.

7.9.Энэ журмын 7.7-7.8-д зааснаас бусад сургууль, дамжаанд элсэгч нарын сонгон шалгаруулалтаар авсан оноогоор эрэмбэлж, зарлагдсан сургууль, дамжааны сонгон шалгаруулалтад өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу оролцох бөгөөд элсэгч нарын оноо тэнцсэн тохиолдолд Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээний дарааллаар эрэмбэлнэ.

7.10.Онолын цогцолбор шалгалтын даалгаврыг тухайн сургууль, дамжааны онцлог, суралцах цар хүрээнээс хамаарч байнгын комисс боловсруулж, комиссын даргаар баталгаажуулна.

7.11.Элсэгч нь өөрийн хувийн дугаар (шифр)-ыг шалгалтын хэвлэмэл цаас, комиссоос боловсруулсан тестийн материал, байр зүйн зураг дээр тэмдэглэнэ. Шалгалтын материалд цол, овог, нэр, анги, байгууллага, албан тушаал, бүртгүүлсэн сургууль, дамжааны нэр болон өөр бусад ямар нэгэн тэмдэг, тэмдэглэгээ тавихыг хориглоно.

Найм. Сонгон шалгаруулалт зохион байгуулах

8.1.Сургууль, дамжаанд суралцах сонсогч, суралцагчийг сонгон шалгаруулах ажиллагааг “Батлан хамгаалах салбарын сургалтын цахим систем”-ээр зохион байгуулж явуулна.

8.2.Үндэсний батлан хамгаалахын их сургуулийг батлан хамгаалах удирдлагын академид элсүүлэх мэргэжил, хяналтын тооны хуваарийг жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор сургалтын цахим системд байршуулна. Гадаадын сургууль, дамжааны хуваарь, мэргэжил, хяналтын тоог сургалтын цахим системд байршуулж, сонгон шалгаруулалтын зарлал, мэдээллийг тухай бүрт БХЯ, ЗХЖШ-ын цахим хуудас, “Соёмбо” сониноор дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ.

8.3.Сургууль, дамжааны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч, иргэн, ажилтан албан хаагч энэ журмын 8.1-т заасан сургалтын цахим системд бүртгүүлнэ.

8.4.Сургалтын цахим программд ирүүлсэн хүсэлтийг БХЯ хүлээн авч, нэгтгэн энэ журмын 5-6 дугаар зүйлд заасан шаардлага, баримт бичгийн бүрдүүлбэрийн дагуу бүртгэлийг баталгаажуулна.

8.5.Сонгон шалгаруулалтын шаардлага, баримт бичгийн бүрдүүлбэр хангасан цэргийн алба хаагч, иргэн, ажилтан албан хаагчийн бүртгэлийн цахим системд баталгаажуулж, сонгон шалгаруулалтад оролцох эрх олгоно.

8.6.Сургалтын цахим системд бүртгүүлсэн элсэгч бүрд цахим системд нэвтрэх нэр, нууц үг, хувийн дугаар (шифр) олгох бөгөөд элсэгч нь өөрийн цахим системийн хувийн дугаараар цахим системээс сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүнтэй танилцана.

8.7.Сургууль, дамжаанд суралцах сонсогч, суралцагчийг сонгон шалгаруулах ажиллагааг сонгон шалгаруулалтад оролцохоор бүртгүүлсэн бүртгэл, баримт бичиг, материалын бүрдүүлбэр, бүртгэлийн баталгаажилт, эрүүл мэндийн үзлэг, бие бялдрын болон онолын цогцолбор шалгалтаар зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтын нэгдүгээр шат болон бие бялдрын шалгалтад тэнцээгүй элсэгчийг онолын цогцолбор шалгалтад оролцуулахгүй.

8.8.Элсэгч нь сонгон шалгаруулалтын материал, дүнтэй танилцах эрхтэй ба сонгон шалгаруулалт бүрийн төгсгөлд дүн гарснаас хойш 2 цагийн дотор сонгон шалгаруулалттай холбогдуулан гомдол гаргаж болох бөгөөд гомдолдоо ямар төрлийн шалгалттай холбоотойгоор гомдол гаргаж байгаа талаарх үндэслэл, тайлбарыг дэлгэрэнгүй бичсэн байвал зохино.

8.9.Сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн цэргийн алба хаагч, ажилтан албан хаагч нь энэхүү журмын 5-6 дугаар зүйлд заасан шаардлага, баримт бичгийн бүрдүүлбэр хангаагүй, эсхүл тухайн ТЦК, анги, байгууллагын ажлын зайлшгүй шаардлага болон сахилга, ёс зүйн зөрчлийн талаарх саналыг үндэслэн сонгон шалгаруулалтын бүртгэлийг баталгаажуулахгүй.

8.10.Сонгон шалгаруулалтын хүрээнд зохион байгуулж байгаа шалгалтын үед бусдаас дэмжлэг авах, бусдад нөлөөлөх, бусдад туслах, урьдчилан бэлтгэсэн материал болон гар утас, бусад техник хэрэгсэл ашигласан элсэгчийг комиссын шийдвэрээр сонгон шалгаруулалтаас хасна.

8.11.Комисс нь сонгон шалгаруулалтын цахим бүртгэл баталгаажсан элсэгчдийн нэрийн жагсаалтыг нэгтгэн гаргаж, Цэргийн төв эмнэлэгт хүргүүлэх ба тус эмнэлэг нь элсэгчдийн нэрийн жагсаалтын дагуу элсэгчдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, элсэгч бүрийн эрүүл мэндийн дүгнэлтийг комисст ирүүлнэ.

8.12.Дараах шалгуур шаардлага хангасан, элсэлтийн ерөнхий шалгалтын өгсөн, эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн иргэнийг биеийн тамирын шалгалт авахгүйгээр цэргийн сургуульд комиссын шийдвэрээр шууд элсүүлж болно:

8.12.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн (Байгалийн шинжлэх ухаан болон гадаад хэлний чиглэлээр);

8.12.2.ОХУ-ын цэргийн дунд сургууль (Суворов, Кадетийн зэрэг)-ийг тухайн жилдээ хамгийн өндөр үнэлгээтэй төгссөн 2 хүртэл тооны хүүхдийг гадаад, дотоодын цэргийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт;

8.12.3.Ерөнхий боловсролын “Тэмүүжин-Өрлөг” бүрэн дунд сургуулийг тухайн жилдээ хамгийн өндөр үнэлгээтэй төгссөн 2 хүүхдийг ОХУ-ын цэргийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт.

8.13.ХБНГУ, Япон, БНТУ-ын цэргийн их, дээд сургуульд элсэгчдийг ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургууль, Аюулгүй байдлын дээд сургуулийн 2 дугаар дамжааны сонсогч, оюутан нараас 2 жилийн сурлагын дүнгээр жагсааж сонгон шалгаруулалтад оролцуулах ба шалгалтыг тус улсын Элчин сайдын яамнаас зохион байгуулна.

8.14.Энэ журмын 8.12-т зааснаас бусад гадаадын сургууль, дамжаанд суралцах элсэгчдийн сонгон шалгаруулалтыг комисс зохион байгуулна.

8.15.Батлан хамгаалах удирдлагын академийн сургалтын тусгай хөтөлбөрийн дагуу энэ журамд заасан шаардлага, баримт бичгийн бүрдлийг хангасан, элсэлтийн шалгалтад тэнцсэн суралцагчийн эчнээ сургалтыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулж явуулж болох бөгөөд эчнээ сургалтын хугацаа 3 жил байх ба 1 жилд суралцах суралцагчийн тоог Батлан хамгаалах яамнаас тогтооно.

8.16.Төрийн цэргийн байгууллагын бүрэлдэхүүний батлан хамгаалахын удирдлагын академид суралцуулах элсэлтийг 2 жилд нэг удаа зохион байгуулах

бөгөөд тэдгээрт журмын 8.14-т заасан эчнээ сургалтад хамаарахгүй.

8.17. Батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагаа, Төрийн цэргийн байгууллагуудын захиалга болон цэргийн алба хаагч /офицер/-ын мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх хүрээнд ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академид элсэгчийг сонгон шалгаруулна.

8.18. Шалгалтын материалыг боловсруулах, дүгнэх, материалын нууцлалыг хадгалах, баталгаажуулах, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны талаар нотломж үйлдэх, архивлах, баримтжуулах, гомдол, маргааныг шийдвэрлэх асуудлыг комисс хариуцна.

Ес. Сургууль, дамжаанд сонсогч, суралцагчийг суралцуулах

9.1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн элсэгчийг комиссын саналыг үндэслэн дотоод, гадаадын сургууль, дамжаанд суралцуулах асуудлыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар шийдвэрлэж, суралцагч бүртэй Төрийн захиргааны удирдлагын газар "Сургууль, дамжаанд суралцуулах гэрээ" байгуулна.

9.2. Гадаадын сургууль, дамжааны сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчид Батлан хамгаалахын сайдын тушаалаар ҮБХИС-ийн гадаад хэлний болон бусад нэмэлт сургалтад хамруулж болно.

9.3. Гадаадын сургууль, дамжаанд суралцах эрх үүссэн суралцагчийн холбогдох материалыг шийдвэрийн хамт суралцуулагч улсын Элчин сайдын яам, холбогдох байгууллагад хүргүүлэх, дотоодын сургууль, дамжаанд суралцах сонсогч, суралцагчийн материалыг шийдвэрийн хамт Үндэсний батлан хамгаалахын их сургуульд хүлээлгэн өгнө.

9.4. Гадаадын сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах суралцагчийг цэргийн анхан шатны бэлтгэлд хамруулах, цэргийн тангараг өргүүлэх, цэргийн цол олгох, дүрэмт хувцсаар хангах асуудлыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар зохион байгуулна.

9.5. Гадаад улсын Зэвсэгт хүчний алба хаагчийг элсүүлэн суралцуулах, асуудлыг батлан хамгаалахын гадаад харилцаа, цэргийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэнэ.

9.6. Гадаадын сургууль, дамжаанд суралцагчийг суралцах хугацаандаа дотоодод хийх дадлагыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, гадаад улсад явагдах дадлагад оролцох суралцагчийн тоо, зардлыг тухайн улстай харилцан тохиролцсоны үндсэн дээр зохион байгуулна.

9.7. Дотоод, гадаадын цэргийн сургууль, дамжаанаас бусад гадаадын сургууль, дамжаанд цэргийн мэргэжлээс бусад мэргэжлээр батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх, эзэмшсэн мэргэжлийг нь дээшлүүлэх, мэргэшүүлэхээр батлан хамгаалах, Зэвсэгт хүчний захиалгаар гэрээний үндсэн дээр сонгон шалгаруулалтад тэнцсэн элсэгч /цэргийн алба хаагч/-ийг суралцуулж болох бөгөөд суралцагчийн төлбөр, суралцах хугацааны зардлыг захиалагч байгууллага хариуцна.

9.8. Офицер, ахлагч, ажилтан албан хаагч нь дотоод, гадаадын сургууль, дамжаанд урт хугацаа (6 сар ба түүнээс)-гаар суралцахаар бол Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу албан тушаалаас чөлөөлж, Батлан хамгаалах яамны мэдэлд шилжүүлнэ. Богино хугацааны сургалт, дамжаанд суралцах суралцагчийн албан тушаалыг хэвээр хадгалж, цалин хөлсийг олгоно.

9.9.Төрийн цэргийн байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь яамны захиалгат хуваарьт өөрийн алба хаагчийг суралцуулах хүсэлт гаргасан тохиолдолд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагын шийдвэрээр тухайн алба хаагчийг гадаадын цэргийн сургуулийн сонгон шалгаруулалтад хамруулах, суралцуулахад энэхүү журмыг баримтална. Суралцагчийн суралцах хугацааны цалин хөлс, бусад зардал, хангалтыг тухайн байгууллага нь хариуцна.

9.10.Батлан хамгаалах удирдлагын академийн сонсогч суралцах хугацаандаа хөдөлмөрийн чадвараа 3 сараас дээш түр хугацаагаар алдсан болон бусад хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд цэргийн академиас түр чөлөөлөгдөх, буцаж нөхөж суралцах асуудлыг яамны Төрийн захиргааны удирдлагын газарт өргөдөл гаргаж шийдвэрлүүлнэ.

9.11.Дотоодын сургууль, дамжаанд суралцаж буй сонсогч, суралцагч хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүд, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд тухайн сургууль, дамжааны эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэн хариуцлага хүлээлгэж, сургалт, дамжаанд 2 жилийн хугацаанд хамруулахгүй. (Суралцсан хугацааны төлбөр төлүүлэх)

9.12.Нэг сургуульд 2 ба түүнээс дээш сонсогч суралцаж байгаа бол ахлах дамжааны сонсогч нь, нэг дамжаанд суралцаж байгаа бол цэргийн цолоор ахлах нь тухайн сургуулийн үндэсний бүлгийн ахлах байна. Хэрэв 10-аас дээш суралцагч суралцаж байгаа тохиолдолд тухайн улс дахь манай цэргийн атташегийн саналыг үндэслэн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар үндэсний бүлгийн ахлагчийг томилно.

9.13.Сургууль, дамжаагаа амжилттай төгссөн суралцагчийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар албан тушаалд томилох, эсхүл Зэвсэгт хүчний Жанжин штабт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

9.14.Гадаадын цэргийн сургуульд бакалаврын хөтөлбөрт хамрагдаж буй цэргийн алба хаагчдад жил бүрийн зуны амралтаар нь 3 хоногийн хугацаатай цэргийн хэргийн мэдлэгийг батжуулах сургалтыг ҮБХИС хариуцан зохион байгуулна. Сургалтын хөтөлбөрийг хэддүгээр дамжаанд суралцаж буйгаас шалтгаалан өөр өөр байна.

9.15.Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдын яамнаас зохион байгуулсан (БХЯ-аас зохион байгуулаагүй) сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн улсад суралцсан суралцагч төгсөж ирээд Зэвсэгт хүчинд ажиллах хүсэлтээ Батлан хамгаалах яаманд гаргана.

9.16.Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу Гадаад улсын боловсролын болон сургалтын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

Арав.Бусад

10.1.Сургууль, дамжаанд сургууль, дамжаанд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн давуу эрхийн баталгаа, цалин хөлс, ахуй хангалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

10.2.Дотоодын цэргийн сургалт, дамжаа хоорондын хугацааг Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталсан цэргийн мэргэжлийн боловсрол олгох, шаталсан сургалтын тогтолцоонд заасан хугацааг баримтална.

10.3.Гадаадын цэргийн сургууль, академид суралцаж төгссөнөөс хойш 24 сар, гадаадын сургалт, дамжаанд суралцаж төгссөнөөс хойш 6 сар, шинэ албан тушаалд

томилогдоод 12 сар (анги, байгууллага дотроо дэвшин болон сэлгэн томилогдсон тохиолдолд 12 сар ажилласан байх шаардлага хамаарахгүй) болон түүнээс дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд гадаадын цэргийн сургууль, академи, сургалт, дамжааны сонгон шалгаруулалтад оролцох эрх нээгдэнэ.

10.5. Сонсогчийг цэргийн анхан шатны бэлтгэлд хамруулах, дүрэмт хувцсаар хангах, бусад хангалтыг цаг хугацаанд нь олгоно.

10.6. Гадаад улсын элсэн суралцагч болон гадаадын сургууль, дамжаанд суралцагчийн суралцах хугацаанд эдлэх хөнгөлөлт, тээвэр, байр ахуйн зардал, тэтгэлэг болон бусад хангалтыг хоёр улсын Батлан хамгаалах яамд хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр болон тусгай журмаар зохицуулна.

10.7. Батлан хамгаалах удирдлагын академид орон нутгаас суралцаж буй суралцагчийн хүсэлт, орон сууцны хангалтын хүрэлцээнд тулгуурлан суралцах хугацаанд нь орон сууцаар хангах асуудлыг Үндэсний батлан хамгаалахын их сургууль хариуцан шийдвэрлэнэ.

10.8. Төрийн цэргийн бусад байгууллагаас батлан хамгаалах удирдлагын академид суралцаж буй сонсогч, суралцагчдын цалин хөлс, орон байр, бусад хангалтыг үндсэн байгууллага хариуцна.

10.9. Сонсогч, суралцагч нарт цэргийн цол олгох, төрийн одон, медаль, батлан хамгаалах салбарын шагналаар шагнах, урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, "Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд", "Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам" болон бусад эрх зүйн актаар зохицуулна.

10.10. Дотоодын сургууль, дамжаанд суралцаж буй сонсогч, суралцагчийн суралцах хугацаанд нь сургалтын материал хэрэгсэл, тоног төхөөрөмж, нөхцөл боломжоор хангах асуудлыг Үндэсний батлан хамгаалахын их сургууль хариуцна.

10.11. Суралцаж буй улс орны болон дотоодын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүд, ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн сонсогч, суралцагчийг тухайн суралцагч улсын саналыг үндэслэн сургууль, дамжаанаас хас ч, хариуцлага хүлээлгэнэ.

10.12. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Батлан хамгаалахын сайдын 2025 оны

02. дугаар сарын 24-ны өдрийн

А/59.. дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт

ДОТООДЫН ЦЭРГИЙН АКАДЕМИ, СУРГАЛТ, ДАМЖААНД
СУРАЛЦАХ СУРАЛЦАГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН КОМИСС

Ажлын хэсгийн дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга;

- Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн шинжээч;

- Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны дарга;

- Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалт бэлтгэлийн газрын дарга;

- Зэвсэгт хүчний Жанжин штабын Хүний нөөцийн хэлтсийн дарга;

- Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны орлогч дарга;

- Батлан хамгаалах их сургуулийн сургалт хариуцсан дэд захирал;

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн хөгжлийн бодлого, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн;

---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
06 дугаар сарын 24-ны өдрийн
12 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ГАДААДЫН ЦЭРГИЙН АКАДЕМИ, СУРГУУЛЬ, ДАМЖААНД СУРАЛЦАХ
СУРАЛЦАГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН
КОМИСС

Ажлын хэсгийн дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Гишүүд:

- Гадаад хамтын ажиллагааны газрын шинжээч;

-Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн дарга;

- Төрийн захиргааны удирдлагын газрын хүний
нөөцийн шинжээч;

- Батлан хамгаалахын Ерөнхий хянан
шалгагчийн Ажлын албаны дарга;

- Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалт
бэлтгэлийн газрын дарга;

- Зэвсэгт хүчний Жанжин штабын Хүний
нөөцийн хэлтсийн дарга;

- Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны орлогч
дарга;

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын хүний
нөөцийн хөгжлийн бодлого, сургалт хариуцсан
ахлах мэргэжилтэн;

---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
08 дугаар сарын 14 ны өдрийн
139 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

СУРГУУЛЬ, ДАМЖААНД СУРАЛЦАГЧТАЙ БАЙГУУЛАХ
СУРАЛЦУУЛАХ ГЭРЭЭ

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын Батлан хамгаалах яамыг төлөөлж Төрийн захиргааны удирдлагын газрын дарга албан тушаалтай цолтой овогтой (цаашид “Захиалагч” гэх) нөгөө талаас сургууль, дамжаанд суралцах болзлыг хангасан оршин суух хаягтай регистрийн дугаартай албан тушаалтай /цолтой/ овогтой (цаашид “Суралцагч” гэх) нар харилцан тохиролцож, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг тус тус үндэслэн 202... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс 202... оны ... дугаар сарын ... -ны өдрийг хүртэлх хугацаатай дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Батлан хамгаалах яам болон ¹ (дотоод, гадаадын цэргийн сургууль, цэргийн академи болон бусад сургууль, сургалт, дамжаа)-д суралцах цэргийн алба хаагч, ажилтан албан хаагч, иргэн (цаашид “Суралцагч” гэх) хооронд гэрээгээр тусгайлан заах эрх, үүрэг, хариуцлагын хэм хэмжээг тодорхойлоход оршино.

1.2 цолтой овогтой-ийг улсад суралцуулах хугацааны нийт зардал төгрөг болно.

- 1.2.1. сургалтын төлбөр төгрөг
- 1.2.2. цалин, цолны цалингийн зардал төгрөг
- 1.2.3. дүрэмт хувцасны зардал төгрөг
- 1.2.4. тээврийн зардал төгрөг
- 1.2.5. суралцах хугацааны тэтгэлэг төгрөг
- 1.2.6. Бусад зардал төгрөг

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Суралцагчаас Монгол Улсын хууль тогтоомж, тухайн улсын хууль, олон улсын гэрээ, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхийг шаардах;

2.2. Суралцагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу суралцах хугацааны цалин хөлс, бусад тээврийн зардал, байр ахуйн зардлыг олгох;

.Суралцагчтай байгуулсан гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах;

.Гадаадын цэргийн болон бусад сургууль, дамжаанд суралцаж суралцагч, сурагч нь бусдын буруутай үйлдэл, үйл ажиллагааны улмаас гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирсон тохиолдолд тухайн улс дахь элчин сайдын яам, цэргийн атташегаар дамжуулах тухайн суралцагчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах;

¹ Аль сургууль, дамжаанд суралцахыг доогуур зурах

.Суралцагчийн буруутай үйлдлээс шалтгаалан гарсан төлбөр, сургалтын зардлыг нөхөн төлүүлэх;

.Суралцагчид гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, эсхүл суралцаж буй тухайн улсын хууль тогтоомж, ёс заншлыг зөрчсөн тохиолдолд гадаад улсад суугаа Элчин сайдын яам, цэргийн атташе, эсхүл тухайн гадаад улсын сургуулийн ирүүлсэн хүсэлт, шаардлагын дагуу хариуцлага хүлээлгэж, суралцах гэрээг хугацаанаас өмнө цуцлах;

.Суралцагчийн өөрийнх нь хүсэлт, буруутай үйл ажиллагааны улмаас сургуулиас хасагдсантай холбоотой гарсан тээврийн зардал, сургалтын төлбөр, холбогдох бусад зардлыг төлүүлэх;

.Суралцагчийг сургуулиа төгссөний дараа Батлан хамгаалах салбар болон Зэвсэгт хүчний шаардлагатай нэгтгэл, анги, байгууллагад томилж ажиллуулах.

.Харьяа агентлаг, сургуулийг түшиглэн иргэнийг цэргийн анхан шатны бэлтгэлд хамруулж, цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох, ахлагчийн албан тушаалын анхны цолыг олгох асуудлыг шийдвэрлүүлэх.

.Анх удаа цэргийн анхан шатны бэлтгэлд гарч буй суралцагчийг цэргийн дүрэмт хувцсаар 1 удаа хангах ажлыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

.Суралцагч суралцах хугацаандаа хүндээр өвдсөн, гэмтсэн тохиолдолд эмчилгээ хийлгэх, эмчилгээний зардлыг тухайн улс хариуцахаар заасан бол гэрээний биелэлтэд хяналт тавина. Бусад тохиолдолд тухайн цэргийн алба хаагч, ажилтан албан хаагч, сурагчийг Монгол Улсад эргэн ирж эмчлүүлэх арга хэмжээ авна.

Гурав. Суралцагчийн эрх, үүрэг

3.1.Суралцагч нь БХЯ-тай байгуулсан гэрээгээ биелүүлэх;

3.2.Суралцах хугацаандаа тухайн орны хууль тогтоомж, соёл, уламжлалыг хүндэтгэн, эх орон, Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөн, сургуулийн дотоод журмыг мөрдөж, сургуулийн удирдлага, багшийн шаардлагыг биелүүлж, хичээнгүйлэн суралцах;

3.3.Суралцагч нь тухайн суралцаж буй улсад суугаа болон хавсран суугаа Батлан хамгаалахын атташе болон үндэсний бүлгийн ахлахад шууд захирагдаж, санал хүсэлтээ тэдгээрээр дамжуулан яамны Гадаад хамтын ажиллагааны газарт уламжлах;

3.4.Суралцагч нь сургуулиас сурлага, сахилгаар болон өөрийн буруутай бусад шалтгаанаар хасагдсан, хөөгдсөн, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулбал гарсан бүх зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлөх;

3.5.Суралцагч нь сургуулиа төгсөж, эх орондоо эргэн ирснээс ажлын 3 хоногийн дотор суралцсан тухай тайланг яамны Төрийн захиргааны удирдлагын газарт өгөх;

3.6.Цалин хөлс, тээврийн зардал, байр ахуйн зардалтай холбоотой санхүүгийн баримтыг яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүлээлгэж өгөх;

3.7.Суралцуулах тухай гэрээг нотариатаар батлуулах, суралцах улсын визний төлбөр, нисэх буудлын хураамж, академи, коллежид суралцагчдын хоол, хүнсний зардал болон бусад тэмдэгтүүдийн хураамжийг суралцагч өөрөө хариуцах;

3.8.Суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй, өөрийн буруутай үйлдлийн улмаас сургуулиа төгсөж чадаагүй хасагдсан, эсхүл төгсөж ирээд гэрээнд заасан ажиллах хугацаанаас өмнө халагдах тохиолдолд дүрэмт хувцас, замын зардлаас

гадна тухайн жилийн Засгийн газрын тогтоолд заасан цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах төлбөрийн хэмжээгээр төлбөр төлөх (Тухайлбал, сонсогч ОХУ-ын цэргийн дээд сургуульд 5 жил сурахаар гэрээ байгуулж яваад өөрийн буруутай үйлдлээс болж 2 жилийн дараа хасагдаж ирвэл Засгийн газрын 2024 оны 95 дугаар тогтоолд заасны дагуу 2 жилийн хугацааг 14,230,000 төгрөгөөр үржүүлж, 28,460,000 төгрөг төлнө).

3.9.Сургууль, багш, үндэсний бүлгийн ахлагчийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, аливаа асуудлыг цэргийн атташегаар уламжлуулан шийдвэрлүүлэх.

3.10.Суралцагч нь суралцах хугацаандаа тухай улсын цэргийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, эрүүл мэндийн асаргаа, үйлчилгээ авах (зөвхөн гэрээнд заасан эмчилгээ хамаарна).

3.11.Монгол Улсын хууль, тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүд, захирах, захирагдах ёсыг баримтлах;

3.12.Сургууль төгсөж ирээд томилсон газарт офицер, ахлагч, сонсогч нь 5-аас доошгүй жил, ажилтан албан хаагч 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах;

3.13.Шаардлагатай тохиолдолд суралцахаар явахын өмнө суралцах болон аяллаар явах үеийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байх;

3.14.Батлан хамгаалах салбарын дотоод, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хүндэтгэж, сургуулиас зохион байгуулснаас бусад жагсаал, цуглаан, улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх;

3.15.Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэц нөлөөлөх тариа эм бэлдмэл, архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх;

3.16.Шашны аливаа үйл ажиллагаанд хамрагдахгүй байх, өөрийгөө болон бусдыг шашны хэт үзэлд автахаас сэргийлэх;

3.17.Батлан хамгаалах яамнаас сонгосон мэргэжлийн дагуу суралцах бөгөөд мэргэжлийг дур мэдэн солихгүй байх;

3.18.Үндэсний бүлгийн ахлагчаар томилогдсон тохиолдолд суралцагчдын сурлагын байдал, сахилга, хариуцлага, эрүүл мэндийн талаарх мэдээ, тайлан болон цаг үеийн асуудлаар холбогдох асуудлыг тухай бүрд нь тухайн улсад суугаа Элчин сайдын яамны дэргэдэх Цэргийн атташед хүргүүлж байх;

3.19.Суралцаж буй орноос өөр улс орон руу явах бол Батлан хамгаалах яам, тухайн оронд суугаа Элчин сайдын яамны Цэргийн атташед илтгэж зөвшөөрөл авах;

3.20.Суралцагч амралтаараа ирээд яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан тушаалтанд бүртгүүлж, үүрэг чиглэл авах;

3.21.Хууль тогтоомж, цэргийн дүрэм, сургуулийн дүрмийг зөрчсөнөөс үүдэн гарах хариуцлага, төлбөрийг суралцагч болон батлан даагч хариуцах;

3.22.Өөрийн буруутай үйлдлийн улмаас цэргийн бэлтгэлээс хасагдвал, дүрэмт хувцасны зардлыг нөхөн төлүүлнэ.

Дөрөв. Суралцагчийн хүлээх хариуцлага

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд дор дурдсан хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

4.1.Суралцагч өөрийн хүсэлтээр болон өөрийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн сургуулиас хасагдсантай холбоотойгоор гарсан замын зардал, сургалтын төлбөр болон холбогдох бусад зардлыг суралцагч, түүний батлан даагч нь хариуцаж

Батлан хамгаалах яаманд нөхөн төлөх;

4.2.Суралцах хугацаандаа сургуульдаа болон бусад хуулийн этгээдэд эд хөрөнгийн хохирол учруулбал өөрөө хариуцан хохиролгүй болгох;

4.3.Суралцагч нь цэргийн бус хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн болон асаргаа, үйлчилгээ авснаас үүдэн гарсан эмчилгээний зардлыг өөрөө хариуцах;

4.4.Офицер, ахлагч, сонсогч, ажилтан албан хаагч нь сургуулиа төгсөж ирээд Зэвсэгт хүчинд 5-аас доош жил ажиллаад өөрийн хүсэлтээр цэргийн албанаас чөлөөлөгдөх бол дутуу ажилласан жилээс хамааран суралцсан хугацааны зардлыг төлөх; (огт ажиллаагүй бол 100 хувь, 1 жил ажилласан бол 80 хувь, 2 жил ажилласан бол 60 хувь, 3 жил ажилласан бол 40 хувь, 4 жил ажилласан бол 20 хувь байна);

4.5.Суралцах хугацаандаа өвчний болон ар гэрийн гачигдлаар чөлөө авах бол түүнтэй холбогдсон бүх зардлыг өөрөө хариуцах;

4.6.Тухайн сургуулиас суралцах хугацаандаа санаатайгаар зайлсхийсэн, оргосон, анги, байрлалаа дур мэдэн орхиж явсан, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, сураггүй алга болсон болон сургууль төгсөөд эх орондоо ирээгүй тохиолдолд Эрүүгийн хуулийн холбогдох заалтын дагуу хуулийн хариуцлага хүлээх;

4.7.Гэрээний 3 дугаар бүлэгт заасан үүргүүдийг зөрчсөний улмаас сургуулиас хасагдсан тохиолдолд холбогдох төлбөр тооцоог төлүүлж, хуульд заасан хариуцлага.

Тав. Сургалтын төлбөрийн хариуцлага

5.1.Сургуульдаа суралцахгүй болсонтой холбогдох зардлыг Батлан хамгаалах яам суралцагчаар дараах байдлаар төлүүлнэ:

5.1.1.ар гэрийн гачигдал, эрүүл мэндийн шалтгааныг нотлох баримтаар нотлохгүйгээр суралцах эрхээсээ татгалзсан тохиолдолд зардлыг бүрэн төлөх;

5.1.2.суралцагч хичээлийн хөтөлбөрийг бүрэн хангаагүй, сурлагын шаардлага хангаагүйн улмаас хасагдсан тохиолдолд (сурлагын дүн тавигдсан шаардлагад хүрэхгүй талаар тухайн улсын зүгээс суралцуулах боломжгүй талаар албан ёсоор мэдэгдсэн), гэмтлийн улмаас хасагдсан тохиолдолд (өөрийн буруутай үйлдлээс болж эрүүл мэндээрээ хохирсон) зардлыг бүрэн төлөх;

5.1.3.суралцагч өөрийн хүсэлтээр болон сахилгын зөрчил гаргаж сургуулиас гарах тохиолдолд зардлыг бүрэн төлөх;

5.1.4.суралцагч гэрээний 3 дугаар бүлэгт заасан үүргээ биелүүлэхээс татгалзах болон өөрийн хүсэлтээр цэргийн албанаас чөлөөлөгдөх бол суралцсан хугацааны бүх зардлыг төлүүлж, цэргийн албанаас бэлтгэлээр чөлөөлнө.

5.1.5.суралцагч зайлшгүй шалтгаанаар буцаж ирсэн тохиолдолд (давтагдашгүй хүчин зүйл, тухайн улсад болж буй иргэний дайн, зэвсэгт мөргөлдөөний улмаас суралцах боломжгүй болсон) гэрээний зардлыг төлөхгүй.

Зургаа. Бусад

6.1.Суралцагчийн суралцах эрхийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар цуцална.

6.2.Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайдын яам (Батлан хамгаалахын атташегийн алба), эсвэл тухайн улсын яамны холбогдох асуудал эрхэлсэн нэгжийн болон дотоодын сургуулийн тодорхойлолтыг үндэслэн сурлага, сахилгын зөрчлийн улмаас суралцах эрхээс татгалзуулах асуудлыг шийдвэрлэнэ.

6.3. Гэрээний 4 дүгээр зүйлийн холбогдох заалтыг зөрчиж эх орондоо буцаж

ирсэн цэргийн алба хаагч эхний ээлжид тухайн улстай холбогдох төлбөр тооцоог буцаж ирснээс хойш 1 сарын дотор төлж барагдуулна. Шаардлагатай тохиолдолд өөрсдийн зардлаар тухайн улсад зорчиж, төлбөр тооцоог хийж дуусгана.

6.4.Суралцагч нь байгуулсан гэрээний холбогдох заалтыг зөрчсөний улмаас энэхүү гэрээ цуцлагдсан тохиолдолд тухайн цэргийн алба хаагчийг цаашид Үндэсний батлан хамгаалахын их сургуульд цэргийн мэргэжлээр үргэлжлүүлэн суралцуулахгүй.

6.5.Цуцлагдсан гэрээг Батлан хамгаалах яамны архивд хадгалж, шаардлагатай тохиолдолд хувийг авч болно.

6.7.Батлан даагчтай байгуулж буй гэрээ нь энэхүү гэрээний салшгүй нэгэн хэсэг байна.

6.8.Суралцах гэрээг байгуулахад сургалтын төлбөрөөс шалтгаалж ахлагч, сонсогч нь 10 сая хүртэлх төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө, барьцаа хөрөнгийг барьцаална. (суралцах, төгсөж ирээд ажиллах хугацаанд);

6.9.Гэрээний оролцогч талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож, хавсралт хэлбэрээр оруулна.

ТАЛУУДЫН БАЙНГЫН ХАЯГ:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энх тайвны өргөн чөлөө-51,
Засгийн газрын 7 дугаар байр

Суралцагчийн хаяг:

.....

.....

Шаардлагатай үед холбоо барих
хүний утас:

.....

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

.....

оны ... дугаар сарын ... -ны өдөр

СУРАЛЦАГЧ

/

оны ... дугаар сарын ... -ны өдөр